



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 03 дугаар  
сарын 15 ны өдөр

Дугаар Хэрг  
1510

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.ОЮУН-ЭРДЭНЭ,  
Х.НЯМБААТАР НАР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Хэнтий аймгийн Бэрхийн уурхайн хувьчлал, уг уурхайд ажиллаж байсан иргэдэд олгох нөхөн төлбөрийн асуудал, цаашид Бэрхийн уурхайн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

002083

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.ОЮУН-ЭРДЭНЭ, Х.НЯМБААТАР  
НАРААС ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ  
ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**Нэг. Бэрхийн уурхайн талаар**

"Бэрх Уул" хувьцаат компани (Бэрхийн уулын үйлдвэр) нь Хэнтий аймгийн Батноров сумын 7 дугаар багын нутаг дэвсгэрт оршдог бөгөөд 63 жилийн түүхтэй Монгол Улсын уул уурхайн ууган үйлдвэрүүдийн нэг юм.

Бэрхийн уурхай нь 1954 оны 9 дүгээр сарын 12-нд Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн "Совмонголметалл" нийгэмлэгийн шийдвэрээр Овоогийн уурхай (одоогийн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг)-н харьяа "Санжаагийн хэсэг" нэртэй байгуулагдсан. Бэрхийн хайлуур жоншны ордыг Хэнтий, Дорнод аймгийн нутагт геологийн судалгаа хийж байсан ЗХУ-ын Дорно дахины геологийн экспедиц, Байгалийн чанд дахь геологи хайгуулын удирдах газрын хэсэг геологичид 1954 оны 9 дүгээр сард ирж уг орд нь ихээхэн нөөцтэй гэсэн үнэлгээ өгч нарийвчилсан хайгуулын ажил явуулах нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргажээ. Үүний дагуу 1955-1957 онуудад Зөвлөлтийн геологи хайгуулын 229 дүгээр анги анги нарийвчилсан хайгуул хийснээр Бэрхийн хайлуур жоншны орд нь нөөц, чанар, эрдсийн агуулгын хувьд дэлхийд дээгүүр орох орд болох нь тогтоогдсон юм.

Тус үйлдвэр нь манай улсын экспортын чухал бүтээгдэхүүн болох хайлуур жонш олборлох үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн 3.6 сая орчим тонн өндөр чанарын жонш олборлон экспортолсон нь улс орны болоод аймаг, орон нутгийн эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулсаар байна.

***Хамтарсан уул уурхайн үйлдвэр болж эрчимтэй хөгжсөн үе:***

Монгол Улсын аж үйлдвэр, уул уурхайн салбарт томоохон байр суурь эзэлдэг "Монголсовцветмет" нэгдэл (одоогийн "Монголросцветмет" нэгдэл) 1973 онд байгуулагдахдаа Бэрхийн уурхайг өвлөн авч гараагаа эхэлсэн нь тус уурхайг хөгжил дэвшлийн шинэ шатанд гаргасан юм.

Уг уурхайг 1973 оноос ЗХУ-ын хүч хөрөнгөөр өргөтгөн орчин үеийн үйлдвэрийн түвшинд хүргэсэн учир цаашид "Бэрхийн уулын үйлдвэр" гэж нэрлэгдэх болсон ба жилд 40 мян.тн экспортын жонш олборлох хүчин чадалтай болсон.

Бэрхийн уулын үйлдвэрийг 1985 онд ЗХУ-ын хүч хөрөнгөөр дахин өргөтгөж жилд 120 мян.тн хүртэл экспортын жонш олборлох хүчин чадалтай болгожээ. Энэхүү өргөтгөлөөр уул уурхайн комплекс байгууламжийн зэрэгцээ уурхайчдын тосгонд 600 айлын тохилог орон сууц, 1000 хүүхдийн дунд сургууль, 50 ор бүхий сум дундын эмнэлэг, 280 хүүхдийн ясли цэцэрлэгийн комбинат, 400 хүний суудал бүхий соёлын төв, 100 суудал бүхий гуанз, ахуйн үйлчилгээний төв, цахилгаан, дулааны станц, усан хангамжийн барилга байгууламж, цэвэрлэх байгууламж зэрэг нийгэм, соёл, аж ахуйн олон барилга байгууламжийг барьж байгуулсан байна. Үүний үр дүнд манай орны зүүн хязгаарт орчин үеийн томоохон суурин болох Бэрх хотхон бий болсон юм.

Бэрхийн уулын үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж нийт ажиллагсдын тоо 800 гаруй болсонтой холбоотойгоор Бэрх хотхоны хүн амын тоо нэмэгдэж 5000 гаруй оршин суугчидтай болсон.

Бэрхийн уулын үйлдвэрийн түүхэнд 1988 онд хамгийн их буюу 180 мян.тн хайлуур жонш олборлон экспортолсон нь хамгийн дээд үзүүлэлт болж байсан байна.

### ***Зах зээлийн үед үйлдвэрлэлийг тогтворжуулах үе:***

1990-ээд оны дундаас Бэрхийн уулын үйлдвэрийн олборлох нөөцийн хэмжээ багасч, уул геологийн нөхцөл хүндэрснээс үйлдвэрлэлийн хэмжээ буурч, өртөг зардал өссөнөөс үүдэн ихээхэн хэмжээний алдагдалтай ажиллах болсон байна.

Бэрхийн уулын үйлдвэрт тохиолдсон бэрхшээлийг даван туулах талаар “Монголросцветмет” нэгдлээс шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Тухайлбал: Баяжуулах фабрикийг 1994 онд ашиглалтанд оруулснаар жилд 46 мян.тн өндөр чанарын жоншны бүтээгдэхүүн гаргах болжээ.

Мөн Тохойбулагийн алтны ордод өөрийн хүч хөрөнгөөр геологи хайгуулын ажил хийж уг алтны ордыг ашиглалтанд оруулсан бөгөөд мал аж ахуй, газар тариалан эрхлэх зэргээр туслах аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Түүнчлэн, Өндөрхаан-Бэрхийн 1,2 сая долларын өртөгтэй 110 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/6 кв-ын дэд өртөөг “Монголросцветмет” нэгдэл өөрийн хөрөнгөөр барьж байгуулан ашиглалтанд оруулснаар тус үйлдвэр, хотыг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах боломж бүрдэж, дэд бүтцийн хувьд сайжирсан.

## **Хоёр. Асуулгын хариу**

### ***Хариулт 1. Бэрхийн уурхайн хувьчлалын талаар***

Дээр дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн алдагдал тодорхой хэмжээгээр буурсан ч зах зээлийн шилжилтийн хүнд үед “Монголросцветмет” нэгдэл ихээхэн хэмжээний алдагдал үүрэх болсон.

Иймээс 1999 онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58 дугаар зүйл, “Монголросцветмет” нэгдлийн Зөвлөлийн ээлжит бус XXVI хурлын протоколын 6.2 дугаар заалтын дагуу Бэрхийн уулын үйлдвэрийг “Монголросцветмет” нэгдлийн бүрэлдэхүүнээс гаргаж, 1999 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн “Бэрх Уул” ТӨҮГ-ыг байгуулсан.

Улмаар Төрийн өмчийн хороо нь “Бэрх Уул” ТӨҮГ-ыг 2001 оноос “Бэрх Уул” хувьцаат компани болгон зохион байгуулж, тус уурхайн Төрийн өмчит нийт хувьцааны 67 хувийг “Эрдэнэс” менежментийн багт 2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан өмчлөгчийн эрхийг шилжүүлж, 33 хувь буюу 6290487 ширхэг хувьцааг 2005 онд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 94 357 050 төгрөгөөр нийтэд худалдсан байна.

“Петровис” ХХК нь 2005 онд нийт хувьцааны дийлэнх хувийг худалдан авсан бол “Файрборд глобал мастер фанд” ХХК нь 2011 онд нийт хувьцааны 99.8 хувийг худалдан авснаар өнөөдрийг хүртэл хэд хэдэн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

-2011 онд тус ордын үлдэгдэл нөөцийг тодотгох зорилгоор нийт 1729.6 уртааш метр 7 цооног өрөмдүүлсэн;

-2014 онд Дэлгэрхааны хайлуур жоншны орд газрыг далд уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ-ийг боловсруулан 2014 оны 5 дугаар сард Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн;

-2011 онд тус компанийн хуримтлагдсан өглөг болон нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгүүдийг бүрэн төлж барагдуулсан байна

Уг компани нь сүүлийн жилүүдэд ажилчдын цалинг 2011 онд 58.19%, 2013 онд 42.2%, 2017 онд 38.7%-иар тус тус нэмсэн бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл, татварт нийт 1.7 тэрбум төгрөг төлсөн байна.

Өнөөгийн байдлаар уг компанийн 99.8%-ийг “Файрборд глобал мастер фанд” ХХК эзэмшиж байгаа хэдий ч Монголын хөрөнгийн биржээр арилжаалагддаг 200 орчим хувьцаа эзэмшигчтэй олон нийтийн компани юм.

## ***Хариулт 2. Бэрхийн уурхайчдын нөхөн олговрын асуудал***

1999 онд шинэчлэн найруулсан Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг нь харгалзан 5, 7, 9, 18 сарын цалингийн дундажтай тэнцэх нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа, ажилтан ажлаа хийж байгаад үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан тохиолдолд ар гэрт нь 36 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг ажил олгогч олгохоор хуульчилсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.4-д “Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой /51 буюу түүнээс дээш хувьтай/ хуулийн этгээд татан буугдсан, төлбөрийн чадваргүй болж дампуурсаны улмаас хариуцагчгүй болсон тохиолдолд ажилтанд олгох нөхөн төлбөрийн асуудлыг Засгийн газар, нутгийн захиргааны байгууллага тусгайлан шийдвэрлэж болно” гэж заасныг үндэслэн Засгийн газар 2001, 2003, 2007 онуудад улсын хэмжээгээр 2659 хүнд 610 гаруй сая төгрөг, 2011 онд 1731 хүнд 486 сая төгрөг, 2012 онд 337 хүнд 94,6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг уурхайчдад тус тус олгосон. Үүний дотор Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан 188 иргэнд 2003 онд 59 сая төгрөг, 2007 онд 18 сая төгрөг, 2011 онд 245 хүнд 68,7 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс олгосон байна.

Түүнчлэн, Бэрхийн уурхайд удаан жил ажилласан, мэргэжлээс шалтгаалах өвчтэй, нөхөн олговор авах бүртгэлтэй хүний тоо 2000 оны байдлаар 326 байснаас 286 нь “Монголросцветмет” нэгдлээс нөхөн олговор авахаар болсон байдаг.

“Бэрх Уул” ХК 2001 оноос хойш мэргэжлээс шалтгаалах өвчний групп болон

үйлдвэрлэлийн осолд орсон 54 хүнд нийт 24.6 сая төгрөгийн нөхөн олговрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

Уг асуудлаар Төрийн өмчийн хорооны даргын 2010 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 85 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, Бэрхийн уурхайд 1999-2004 онд ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн нөхөн төлбөрийн асуудлыг судлан, ажилласан бөгөөд уг Ажлын хэсэгт Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам /тухайн үеийн нэрээр/-аас төлөөлөл орж ажилласан.

Мөн 2013 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Төрийн өмчийн хороо /тухайн үеийн нэрээр/-оос дахин Ажлын хэсэг байгуулж ажилласан бөгөөд уг ажлын хэсгээс нийт 196 хүнд 4.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгуулах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх дүгнэлт гаргасан хэдий ч тухайн үеийн Засгийн газраар асуудлаа оруулаагүй байна.

Иймд Бэрхийн уурхайчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Засгийн газар болон Ерөнхий сайдад нөхөн төлбөр олгох асуудлаар хүсэлт гаргаж байсан бөгөөд 2017 оны 10 дугаар сард Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандан нэхэмжлэл гаргасан байна.

Үүнтэй холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар “Бэрх-Уул” төрийн өмчит хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байсан үед буюу 1999-2004 оны хооронд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаас уг асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон бусад төрийн байгууллагатай хамтран дахин нягтлан үзэж саналаа Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан байна.

Цаашид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтны нөхөн төлбөрийн зохицуулалтыг нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулан боловсронгуй болгох зорилгоор Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах асуудлыг судлан, боловсруулж байна.

### ***Хариулт 3. Бэрхийн уурхайг цаашид ашиглах талаар***

Бэрхийн уурхайн ордын нөөцийг 2012 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн ЭБМЗ-ийн ХХ-17- 11 тоот дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмалын газар /тухайн үеийн нэрээр/-ын даргын 2012 оны 498 дугаар тушаалаар МУ-000166 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах хайлуур жоншны нийт (В+С) зэргээр 50.52%-ийн дундаж агуулгатай 2128931.1 тонн хүдэрт 1075599.9 тон хайлуур жоншны нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.

Дэлгэрхааны ордыг В зэргийн нөөцийн хэмжээнд гүйцээн ашиглах далд уурхайн ТЭЗҮ-ийг 2014 онд боловсруулсан бөгөөд уг ТЭЗҮ-д өмнө нь ашиглагдаж байгаад хаагдсан далд уурхайг дахин нээх, уурхайн үндсэн малталт, дэд бүтцийг сэргээх, одоогоор тогтоогдсон үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий хүдрийн нөөцийг ашиглах, цаашид нөөц өсгөх геологи хайгуулын ажил явуулах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлууд тусгагдсан.

Одоогийн байдлаар В зэрэглэлийн геологийн нөөцийн хэмжээ 490.2 мян.тн гэж тогтоогдсон бөгөөд уг хэмжээний хайлуур жоншны хүдрийн нөөцийг далд аргаар ашиглаж флотацийн баяжуулалтаар боловсруулах нь төслийн эдийн засгийн зардлыг даахааргүй байгааг тооцоолсон байна. Иймд С зэргийн нөөцийн зэрэглэлийг ахиулж, тохирсон хүчин чадал бүхий ТЭЗҮ-ийг дахин боловсруулах шаардлагатай байгаа болно.

Мөн далд уурхайн малталтуудыг нэвтрэх, хүдрийн биет, уулын цулыг буглах ажлуудыг тухайн ордын уул-геологийн нөхцөл, уулын ажлын горим, хүдрийн биетүүд, агуулагч чулуулгын шинж чанаруудаас хамааран "өрөмдлөг тэсэлгээ"-ний аргаар гүйцэтгэхээр байна.

Түүнчлэн, тэсэлгээний ажил хийж гүйцэтгэх тусгай зөвшөөрөл, хүдэр баяжуулах төслийн ТЭЗҮ боловсруулах, нөөцийн зэрэглэлийг өсгөх хайгуул хийх, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотгол хийлгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна.

---ooOoo---